



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 6/11

Ховд

Төслийн кластер хариуцсан зохицуулагч
томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "б", Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн, Хар ус нуур, Цамбагаравын байгалийн цогцолборт газар, Алтан хөхий, Манханы талын байгалийн нөөц газрын улсын тусгай хамгаалалттай газрууд, тэдгээрийн орчны бүс, Эко-коридор нутгуудад биологийн олон янз байдлыг хамгаалах, Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор кластер байгуулах, үйл ажиллагааг нь удирдан зохицуулах талаар оролцогч талууд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь төслийн орон нутаг дахь 2 дугаар кластер хариуцсан зохицуулагч, орон нутгийн багийн ахлагчаар Дүгэрээгийн Одончимэгийг, 4 дүгээр кластерийн зохицуулагчаар Эрдэнийн Удвалыг, 3, 5 дугаар кластерийн зохицуулагч, санхүү хариуцсан ажилтнаар Чулуунбатын Мөнгөнхүү нарыг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус томилсугай.

2.Зохицуулагч нарын гүйцэтгэх ажил үүргийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

3.Төслийн үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэхийг Д.Одончимэг, Э.Удвал, Ч.Мөнгөнхүү нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/11.Ch
02 01093